



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 03 өдөр

Дугаар

А/44

Дуурсах

Г АШУҮИС-ийн багш шавийн уулзалт
зохион байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.24 дэх заалт, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн сургалтын хөтөлбөр, удирдамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн багш шавийн уулзалт, сургалтыг 2022 оны 06 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Уулзалт, сургалтын үйл ажиллагааны удирдамжийг нэгдүгээр, хөтөлбөрийг хоёрдугаар, зохион байгуулах ажлын хэсгийг гуравдугаар, зарцуулагдах төсвийн тооцоог дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Багш шавийн уулзалт, сургалтын арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн гишүүдэд, үйл ажиллагаанд идэвх санаачлагатай оролцож хүндэтгэл үзүүлэхийг нийт эрүүл мэндийн байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Сургалтад зарцуулагдах 1,050,000 (Нэг сая тавин мянга) төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас зарцуулахыг ахлах нягтлан бодогч (П.Мөнх-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (С.Батцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА *Г.Х.Х.Х.* Н.ЭНХЖАРГАЛ



Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
06 дугаар сарын 02-ны өдрийн А/Б.Б.
дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН БАГШ ШАВИЙН УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Зорилго: Монгол улсын хөгжилд тус сургуулийн гүйцэтгэсэн үүргийг олон нийтэд сурталчлан таниулах, шинжлэх ухаан, түүн дотор анагаах ухаан, эмчилгээ, оношилгооны дэвшилтэт технологийн ололт амжилт, инновацыг түгээн дэлгэрүүлэх, төгсөгчдийн ажлын байран дахь тасралтгүй сургалтыг зохион байгуулж, багш шавийн нандин холбоог бэхжүүлэх, орон нутгийн ард иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, зөвлөгөөг үзүүлэх.

Зорилт:

1.Эмч эмнэлгийн мэргэжилтний ажлын байран дахь тасралтгүй сургалтыг зохион байгуулж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах.

2.АШУҮИС-тай гэрээ байгуулж хамтын ажиллагаа уялдаа холбоог сайжруулах.

3.“Анагаах Шинжлэх Ухааны Үндэсний их сургууль-80” баримтат киноны зураг авалтын үйл ажиллагааг зохион байгуулах

Хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 13, 14-ний өдөр

Хамрах хүрээ:

Эрүүл мэндийн газар

Зоонозын өвчин судлалын төв

Нэгдсэн эмнэлэг

Сумын эрүүл мэндийн төв

Өрхийн эрүүл мэндийн төв

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд

Эм холбоо

Хүрэх үр дүн:

Эмч мэргэжилтний мэдлэг мэргэшил дээшилж эмнэлгийн чанар, тусламж үйлчилгээ сайжирна.

Хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоо сайжирна.

Зохион байгуулагдах үйл ажиллагаа:

Нээлтийн үйл ажиллагаа

Эмч, эмнэлгийн мэргэжилтэнд сургалт, уулзалт хийх

АШУҮИС-ийн захирал, Аймгийн Засаг даргатай хамтын ажиллагааны гэрээ байгуулах ёслолын ажиллагаа

“Анагаах Шинжлэх Ухааны Үндэсний их сургууль-80” баримтат киноны зураг авалтын үйл ажиллагаа

Дурсгалын зураг авахуулах

АШУҮИС-ийн багш нарыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
06 дугаар сарын 22-ны өдрийн А.14/5
дүгээр тушаалын 2 дугаар хавсралт



УУЛЗАЛТ, СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

06 дугаар сарын 13-ны өдөр

09.00-09.30 Нээлтийн үйл ажиллагаанд үг хэлэх

- Аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан
- АШУҮИС-ийн дэд захирал Д.Цэрэндавга
- Эрүүл мэндийн газрын дарга Н.Энхжаргал
- Төгсөгчдийн төлөөлөл

09.30-09.40 АШУҮИС-ийн захирал, Аймгийн Засаг даргатай хамтын ажиллагааны гэрээ байгуулах ёслолын ажиллагаа, Дурсгалын зураг авахуулах

09.40-09.55 “Анагаах Шинжлэх Ухааны Үндэсний их сургууль-80” баримтат кино

09.55-10.00 Шагнал гардуулах

10.00-12.00 Нэгдсэн сургалтын арга хэмжээ

10.00-10.30 АШУҮИС-ийн 80 жилийн түүхэн ололт, амжилт

МУ-ын ардын багш, АШУ-ны доктор, профессор Д. Дүнгэрдорж

10.30-11.00 Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн боловсрол ба төлөвшил

11.00-11.45 Кроновирусын халдвар ба жирэмслэлт, төрөлтийнхүндрэл

АУ-ны доктор, профессор Ж. Энхцэцэг

11.45-12.00 Асуулт, хариулт, санал, зөвлөмж

12.00-13.00 Үдийн завсарлага

13.00-18.00 Нутгийн захиалгат сургалт, эрүүл мэндийн үзлэг, зөвлөгөө

Эмч нарт зориулсан сургалт

13.00-13.45 Эмнэлэг доторх яаралтай тусламжийн тогтолцоо, эрт сэрэмжлүүлэх үнэлгээ - АУ-ын доктор М.Наранпүрэв

13.45-14.00 Асуулт хариулт

14.00-14.45 Амьсгалын замын цочмог халдварууд ба ковидын дараах хүндрэл, авах арга хэмжээ- АУ-ын доктор, дэд профессор Г. Эрдэнэтуяа

14.45-15.00 Асуулт хариулт

15.00-15.45 Цусны дэлгэрэнгүй шинжилгээ, цус бүлэгнэлтийн шинжилгээний эмнэлзүйн ач холбогдол- АУ-ны доктор, дэд профессор А. Отгонбат

15.45-16.00 Асуулт хариулт

16.00-16.45 Стероид бус үрэвслийн эсрэг эмийн зохистой хэрэглээ-

АУ-ын доктор, дэд профессор Ч. Ерөөлт

16.45-17.00 Асуулт хариулт

17.00-17.40 Хүүхдийн тусламж үйлчилгээ

АУ-ын доктор, дэд профессор Д.Агиймаа

17.40-18.20 Хэвлийн хэт авиан шинжилгээ

Анагаах ухааны магистр П.Төгсжаргал

17.40-18.30 Дүгнэлт ярилцлага, санал зөвлөмж

18.30 Сургалтын хаалтын ажиллагаа

- АШУУИС-ийн эмнэлэг хариуцсан дэд захирал Д.Цэрэндавга
- Нэгдсэн эмнэлгийн дарга Ч.Жавзан

Сувилагч, тусгай мэргэжилтэнд зориулсан сургалт

13.00-14.00 “Сувилагч мэргэжлийн үнэ цэнэ, эрхэмлэх зүйлс”

Сувилахуйн ухааны доктор Г. Хулан

14.00-14.30 Ярилцлага

14.30-15.30 “Сувилахуйн мэргэжилтнүүдийн ёс зүйн асуудал”

Сувилахуйн ухааны доктор Г. Хулан

15.30-16.00 Ярилцлага

16.00-17.00 Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал

Сувилахуйн ухааны магистр Ж.Сэргэлэнцэцэг

Эм зүй, эм найруулагч нарт зориулсан сургалт

13.00-14.00 “Эм зүйн тусламж үйлчилгээний хөгжил, цаашдын хандлага”

ЭЗУ-ны доктор, дэд профессор С. Мөнхбат

14.00-14.30 Ярилцлага

14.30-15.30 “Эм хангамжийн салбарын хүний нөөцийн хөгжил, боловсрол”

ЭЗУ-ны доктор, дэд профессор Д. Даваадагва

15.30-16.00 Ярилцлага

06 дугаар сарын 14-ний өдөр

09.00-10.00 Баянхонгор аймагтай танилцах үйл ажиллагаа

10.00-12.00 Хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ МУ-ын ардын багш, АШУ-ны доктор, профессор Д. Дүнгэрдорж

12.00-14.00 Үдийн завсарлага

14.00-17.00 Багш нартаа хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ



Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
06 дугаар сарын 02-ны өдрийн А/Б/Г
дүгээр тушаалын 3 дугаар хавсралт

**АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН
БАГШ ШАВИЙН УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ**

Зохион байгуулах комиссын дарга:

1. Т.Хажидсүрэн (Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга)

Зохион байгуулах комиссын гишүүд:

2. С.Батцэцэг (Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга)
3. С.Дуламсүрэн (Эм, эмнэлгийн хэрэгсэл вакцин биобэлдмэлийн чанар, аюулгүй байдал, хариуцсан мэргэжилтэн)
4. А.Булганчимэг (Анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн)
5. Г.Лхагва-Очир (Хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн)
6. Ч.Жавзан (Нэгдсэн эмнэлгийн дарга)
7. Б.Алтанчимэг (Зоонозын өвчин судлалын төвийн дарга)
8. Э.Гүнжинлхам (Өрхийн эрүүл мэндийн төвийн холбооны дарга)
9. П.Дүүрэнхундага (Хувийн хэвшлийн эрүүл мэндийн холбооны дарга)
10. С.Отгонжаргал (Сумын эрүүл мэндийн төвийн эмч нарын холбооны дарга)
11. П.Оюунжаргал (Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн даргыг түр орлон гүйцэтгэгч)
12. Ж.Долгорсүрэн (Эм холбооны дарга)

_____оОо_____

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
06 дугаар сарын 22-ны өдрийн А/144
дүгээр тушаалын 4 дүгээр хавсралт



**АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН
БАГШ ШАВИЙН УУЛЗАЛТАНД ЗАРЦУУЛАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Нэр төрөл	Тоо	Хэмжих нэгж	Давтамж	Нэг бүрийн үнэ /₮/	Нийт шаардагдах үнэ /₮/
1	2	3	4	5	6	7
1	Оролцогчдын бичиг хэргийн зардал	110	Ширхэг	1	7,000	770,000
2	Багш нарын цайны зардал	14	Хүн /цай	2	10,000	280,000
Нийт дүн 1,050,000						

_____оОо_____